

# КОВИД-19-ийн эсрэг авах хариу арга хэмжээ

Асуулт, хариулт

2020 оны 4-р сарын 16

“Сүмийн нэн шаардлагатай ёслол, адислалууд болон Сүмийн бусад үйл ажиллагаатай холбоотой удирдамж заавар” нэртэй баримт материалаас гадна КОВИД-19 цар тахлын үеэр Сүмийг удирдахтай холбоотой асуултуудад хариулахад энэхүү баримтыг ашиглаж болно.

Эдгээр баримтыг КОВИД-19 цар тахлын улмаас Сүмийн үйл явц, гишүүдийн үйл ажиллагаа саарсантай холбогдуулан гаргаж байна. Тухайн улс оронд эсвэл улс орны газар нутгийн аль нэгэн хэсэгт энэ цар тахал, үүнтэй холбоотойгоор Сүмийн цуглаанд болон олон нийтийн албан ёсны хөл хорио тавигдсан байгаа цагт эдгээр баримтыг удирдамж заавар болгон ашиглана. Өөр бусад удирдамж зааврыг хожим нэмж гаргах магадлалтай.

Гадасны ерөнхийлөгч, бишоп нар орон нутгийн нөхцөл байдалд сэргэг бөгөөд анхааралтай хандах хэрэгтэй. Тэд гишүүдээ хууль дүрмийг дагахад урамшуулах ёстой. Доорх асуулт, хариулт бүрд дараах зүйлийг хэрэгжүүлбэл зохино. Үүнд:

- Зай барих, гар угаах болон [newsroom.churchofjesuschrist.org/article/coronavirus-update#preventative-measures](https://newsroom.churchofjesuschrist.org/article/coronavirus-update#preventative-measures) дахь “Preventative Measures for Members” дээрх бусад дадлыг хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийн мэргэжилтнүүд, төрийн удирдагчдын зааварласнаар бие даан тусгаарлах зарчим, аргачлалыг дагаж мөрдөх
- Тухайн газрын засгийн газрын тушаал, журам, удирдамж

КОВИД-19-тэй холбоотой нэмэлт материалыг [newsroom.ChurchofJesusChrist.org](https://newsroom.ChurchofJesusChrist.org)-оос авч үзнэ үү.

Хэрэв маш хүнд төвөгтэй асуулт гарч ирвэл гадасны ерөнхийлөгчид Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлтэйгөө холбогдвол зохино.

## I. Санваарын ёслол ба гэр бүлийн тэмдэглэлт үйл явдлууд

### Ариун ёслолыг хөтлөн явуулах

Гэрт нь зохистой Мелкизедек санваар атгагч эсвэл зохистой прист байдаггүй, тойргийнхоо бусад гишүүний гэрт санваар атгагч нар ариун ёслол гүйцэтгэж болох уу?

*Ерөнхийдөө бол болно. Одоогийн байдлаар, засгийн газрын эсвэл орон нутгийн удирдамж чиглүүлгээр ийн үйлдэх боломжийг олон улс орон, хотод хориглож байна. Эдгээр газарт энэ байдлыг өөрчилсөн мэдэгдэл гаргахаас нааш санваа атгагч нар хамаатан садан бус Сүмийн гишүүдийн гэр оронд ариун ёслол үйлдэхээр очихгүй. Энэ үеэр гишүүд ариун ёслолын залбирлыг судалж, байгуулсан гэрээнийхээ дагуу амьдрахаар өгсөн амлалтаа шинэчилж, санваараар зохих ёсоор адислагдсан ариун ёслолоос өөрийн биеэр хүртэх тэр өдрийн төлөө залбирч болно.*

### Патриархын адислал

Патриархын адислал авах цагийг цаашид товлох уу?

*Патриархын адислалыг түр хугацаагаар хойшлуулах ёстой. Гэхдээ боломжтой бол номлолд явахаар бэлдэж байгаа хүмүүст номлогчийн үйлчлэлээ эхлэхээс нь өмнө патриархын адислал өгсөн байх ёстой.*

## Хурим, хүлээн авалт, оршуулга

Шинэ удирдамжийн дагуу цуглааны байранд хуримын (мөн хүлээн авалт) болон оршуулгын ёслол үйлдэж болох уу?

*Засгийн газрын тогтоолоор хязгаарласан тохиолдолд хурим, хүлээн авалт, оршуулгын ёслолыг цуглааны байранд гүйцэтгэхгүй.*

*Хуулиар зөвшөөрсөн бол гадасны ерөнхийлөгч, бишоп нар хүмүүс хоорондын зайг баримтлан, боломжтой нөхцөлд хуримын ёслолыг гүйцэтгэж болно. Техник технологи ашиглан, гэр бүлийнхэн, найз нөхдөд нь ёслолын ажиллагааг үзүүлж болно. Удирдагч, гишүүд засгийн газрын тушаал, журам, зааврыг дагаж мөрдөх ёстой.*

*Хуульд зөвшөөрснөөр, гадасны болон бишопын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд оршуулгын газар булины дэргэдэх ёслолыг үйлдэж болно. Түүнчлэн гэр бүл, найз нөхдөд нь ёслолыг үзүүлж, бичлэг хийлгэхэд техник технологийг ашиглах боломжтой. Хүсвэл, нөхцөл байдал боломжтой болох үед томоохон дурсамжийн ёслол үйлдэж болно.*

## Хүүхдэд нэр өгч, адислах

Удирдамжийн дагуу хүүхдийг гэртээ адисалж болох уу?

*Болно. Бишопоос зөвшөөрөл авсан тохиолдолд Сүмийн цуглаан дээр биш, харин гэрт нь адисалж болно. Үүнийг зохих ёсоор тайлагнах ёстой.*

## II. Гадас, тойргийг удирдах

### Хурал ба ярилцлага

Гадасны болон бишопын ерөнхийлөгчийн зөвлөлийн мөн дээд зөвлөл болон бусад ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал, ярилцлагыг биеэр уулзан явуулж болох уу?

*Энэ тухай шийдвэрийг орон нутгийнхаа хүрээнд, байгаа мэдээлэл дээрээ тулгуурлан гаргана. Боломжтой бол хурал, ярилцлагыг техник технологи ашиглан хийж болно.*

### Цуглааны ирцийн бүртгэл

Цуглаан хийхийг зогсоосон тул ирцийг хэрхэн тоолж, тайлагнах вэ?

*Ням гаргийн цуглааныг түр хугацаагаар зогсоосон тул ирцийг тайлагнахгүй.*

### Байр, байгууламжийн ашиглалт

Байр, биеийн тамирын талбайг ашиглаж болох уу? Өсвөр үеийнхэн цугларч, цуглааны байрны гаднах зай, талбайд хөл бөмбөг тоглож болох уу?

*Гадас, тойрог, салбарын үйл ажиллагааг тур хугацаагаар зогсоосон байгаа. Хувь хүмүүс “Гишүүдэд зориулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-г дагах ёстой. Гишүүд засгийн газрын тушаал, журам, удирдамжийг дагаж мөрдөх ёстой.*

Спортын арга хэмжээ, найрал дууны давтлага, төгөлдөр хуурын хичээл зэрэг цуглаан байранд өдөр тутмын үйл ажиллагааг явуулж болох уу?

*Спортын арга хэмжээ, найрал дууны давтлага, төгөлдөр хуурын хичээл гэх мэт үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон. Гишүүд засгийн газрын тушаал, журам, удирдамжийг дагаж мөрдөх ёстой.*

Сүмийн байранд долоо хоног тутам явагддаг донтолтоос ангижрах болон бие даах чадвараа хөгжүүлэх ангиудыг хэрхэн вэ?

*Тэдгээрийг техник технологи ашиглан хийх ёстой.*

Гадасны төвд байдаг гэр бүлийн түүхийн төвийг хаах ёстой юу?

*Тийм ээ. Үйлчлүүлэгчид гэрээсээ техник технологи ашиглан хийх ёстой.*

### Институт ба семинар

*Бүх асуултаа СБС-ийн КОВИД-19-ийн эсрэг авах хариу арга хэмжээ (CES guidelines in response to COVID-19)-ээс харна уу.*

### Аравны нэг ба бусад өргөл

Бишопын зөвлөлийнхөн аравны нэг болон өргөлийг биечлэн хүлээн авдаг хэвээр байх уу эсвэл цуглааныг түр зогсоосон энэ хугацаанд зөвхөн цахимаар гүйцэтгэх ёстой юу?

*Боломжтой бол, гишүүд өргөлөө онлайнаар төлөх ёстой. Онлайнаар төлөх боломжгүй бол гишүүд бишопын зөвлөлийн аль нэгэн гишүүнд биечлэн өгч эсвэл Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс боломжгүй гэж үзээгүй тохиолдолд урьдчилан хаягласан дугтуйг ашиглан, шуудангаар илгээж болно. Нэмэлт асуулт байвал Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс асуух хэрэгтэй.*

### ӨҮБББТ чуулган

Өсвөр үеийнхний ӨҮБББТ чуулганыг энэ зун явуулах уу (2020)?

*2020 оны ЗБББТ чуулганыг АНУ, Канадад 2021 онд хийхээр хойшлуулсан. 2020 оны ЗБББТ чуулганд оролцох урилга хүлээн авсан гадаснууд 2021 онд оролцоно. 2021-2023 онд АНУ, Канадад явуулах ЗБББТ чуулганы шинэчлэгдсэн хуваарийг удахгүй*

*оруулна. Бүртгүүлсэн хүмүүсийн төлбөрийн буцаан олголт автоматаар хийгдэнэ. 2020 оны ӨҮБББТ чуулганд оролцох урилга хүлээн авсан өсвөр үеийнхэн насны шаардлагад нийцэж байвал 2021 оны ӨҮБББТ чуулганд оролцож болно. АНУ, Канадаас бусад оронд засгийн газрын өөрийн орон нутаг, улс оронд гаргасан КОВИД-19-тэй холбоотой удирдамжийн дагуу Бүс бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлүүд ӨҮБББТ чуулганыг явуулах эсэх талаар удирдамж гаргах болно. ӨҮБББТ чуулганы талаарх нэмэлт мэдээллийг [FSY.ChurchofJesusChrist.org](http://FSY.ChurchofJesusChrist.org)-оос авна уу.*

### **Ш. Номлолын үйлчлэл**

#### **Номлолын өмнөх**

Орон нутгийн санваарын удирдагчид номлогчийн маягтыг үргэлжлүүлэн боловсруулах уу? Номлогчид ойрын хугацаанд үргэлжлүүлэн дуудагдсаар байх уу?

*Тийм.*

Гадасны ерөнхийлөгч, бишопууд ирээдүйн номлогчидтой биечлэн ярилцлага хийж болох уу?

*Болно. Гэхдээ боломжтой бол ирээдүйн номлогчийн ярилцлагыг нүүр нүүрээ харж ярилцах боломж олгох технологийг ашиглан, зайнаас явуулж болно.*

#### **Номлогчийн амьдрал**

Номлогчид байр байрандаа байх ёстой ч холбогдсон хүндээ биечлэн зааж болох уу?

*Болохгүй. Номлогчид засгийн газрын тушаал, журам, удирдамжаас гадна Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн болон*

*номлолын ерөнхийлөгчийн удирдамж зааврыг дагах ёстой.  
Гэхдээ тэд техник технологи ашиглан заах боломжтой. (Техник  
технологии ашиглан заах тухай номлогчид зориулсан цуврал видео  
бичлэгийг үзнэ үү).*

Номлогчид гудамжинд хүмүүстэй холбоо тогтоож болох уу?

*Номлогчид засгийн газрын тушаал, журам, удирдамжаас гадна  
Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн болон номлолын  
ерөнхийлөгчийн удирдамж зааврыг дагах ёстой.*

Корона вирусын шинж тэмдэг илэрсэн хүнд адислал өгөхийг хэн  
нэгэн номлогчоос хүсвэл адислал өгөх ёстой юу?

*Болохгүй. Номлогчид вирустай болох нь тогтоогдсон, шинж  
тэмдэг илэрсэн эсвэл КОВИД-19 туссан хүнтэй ойрын зайд  
байсан хүмүүстэй очиж уулзаж болохгүй. Тэд техник  
технологииор дамжуулан тэдэнд тохинуулж, тэдний төлөө  
залбирч болно.*

Номлогчид үргэлжлүүлэн үйлчилж, JustServe-тэй хамтарч ажиллах  
ёстой юу?

*Номлогчид засгийн газрын тушаал, журам, удирдамжаас гадна  
Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийн болон номлолын  
ерөнхийлөгчийн удирдамж зааврыг дагах ёстой.*

## Гишүүний номлолын ажил

Гишүүний номлолын ажлыг үргэлжлүүлэн хийж болох уу?

*Болно. Гадасны ерөнхийлөгчийн болон бишопын удирдлаган доор  
хийгдэнэ. Нөхцөл байдал өөрчлөгдөх хүртэл бүрэн цагийн*

*номлогчдод тавигдаж буй биечлэн уулзах хязгаарлалт гишүүний номлогчийн ажилд мөн адил тавигдана.*

## Номлогчийн хурал, цуглаан

Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөн номлолуудаар аялахын оронд удирдлагын зөвлөлийн хуралд болон бүсийн цуглаанд оролцож болох уу?

*Бүсийн цуглаанд номлогчдыг биечлэн оролцохыг түр хугацаанд зогсоосон. Шаардлагын дагуу хурал, цуглааныг техник технологи ашиглан, зайнаас явуулах болно.*

## IV. Ариун сүмийн ажил

### Ариун сүмийн эрхийн бичгийн ярилцлага хийх ба идэвхжүүлэх

Сүмийн гишүүдийг ариун сүмийн хүчинтэй эрхийн бичигтэй байхад урамшуулах уу?

*Тийм. Хүчинтэй ариун сүмийн эрхийн бичиг нь ариун сүмд бишрэн шүтэх боломжгүй ч тухайн хүний зохистой байдлыг хүлээн зөвшөөрдөг.*

Ариун сүмийн эрхийн бичгийн ярилцлагыг биечлэн хийхээ үргэлжлүүлэх үү?

*Үгүй. Гадасны болон бишопын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд нүүр нүүрээ харан ярилцах боломж олгодог техник технологи ашиглан, ариун сүмийн эрхийн бичгийн ярилцлагыг түр хугацаанд хийж болно. Гишүүд нь гадасны болон бишопын ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдийн аль алинтай ярилцлага хийдэг хэвээр байх болно.*

Ариун сүмийн эрхийн бичгийг гарын үсэггүй ч байсан өгөх үү?



*Өгнө. Бишопын зөвлөлийн гишүүд боломжтой техник технологио ашиглан, ярилцлага хийнэ. Ярилцлагын дараа тэд гарын үсэг зуран, зургийг нь аваад, зургаа гадасны бичиг хэргийн ажилтанд явуулна. Тэгээд уг гарын үсэг зурсан ариун сүмийн эрхийн бичгийг гишүүнд хүргэж өгч эсвэл шуудангаар илгээнэ. Гишүүн авсан даруйдаа эрхийн бичиг дээр гарынхаа үсгийг зурна.*

*Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн уг гишүүнтэй ярилцлага хийсний дараа өөрөө эсвэл гадасны бичиг хэргийн ажилтан эрхийн бичгийг гарын үсэггүйгээр идэвхжүүлнэ. Тойргийн ариун ёслолын цуглаан болон бусад хурал цуглаан дахин явагдаж эхлэх үед гарын үсэг зуруулаагүй бүх гишүүн эрхийн бичиг дээрээ гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнээр гарын үсэг зуруулна.*

## **V. Бусад асуулт**

Бид цус өгөх аянд нэгдсэн хэвээр байх хэрэгтэй юу?

*Тийм. Цус өгөх аян явагдсаар байх ч бид тухайн газрын засгийн газрын тушаал, журам, удирдамжийг мөн цус авдаг газруудын (Улаан Загалмайн болон бусад) протоколыг дагах ёстой.*

*Удирдамж заавар иртэл цуглааны байрыг дээрх зорилгоор ашиглаж болохгүй. Харин цуглааны байрын машины зогсоолыг Улаан Загалмайн болон зөөврийн байр ашиглаж байгаа бусад байгууллага, засгийн газрын тушаал, журам, удирдамжийг дагаж байгаа тохиолдолд ашиглаж болно.*

Удирдагчид КОВИД-19 вирус бүхий Сүмийн гишүүдтэй ойрын зайд байсан магадлалтай гишүүдэд тэдний талаар мэдээлэх ёстой юу?

*Ерөнхийдөө болно. Удирдагчид болон тохинуулагч ах, эгч нар ажил үүргийнхээ дагуу өвчилсөн гишүүдтэй холбогдох учраас тэдэнд зөвлөн мэдэгдэх хэрэгтэй. Тэрхүү удирдагч, тохинуулагч ах, эгч нар техник технологиор дамжуулан үргэлжлүүлэн тохинуулж, “Гишүүдэд зориулсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-н дээрх зааврыг дагах ёстой. Гишүүд зохих хууль, дүрэм журам, үүнд засгийн газрын тушаал, дүрэм журам, удирдамжийг дагах ёстой.*

***Нэмэлт асуултуудыг Бүсийн ерөнхийлөгчийн зөвлөлд тавих ёстой бөгөөд тэд шаардлагатай удирдамж зааврыг өгнө.***